



Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар: <i>НАГ-ын захирал бөгөөд</i> <i>тэргүүлэх аудиторын</i> <i>албан үүргийг түр</i> <i>орлон гүйцэтгэгч</i> <i>Х.Болдбаатар</i> Аудитор <i>Д.Дорждаулам</i> <i>Л.Нямтөмөр</i> 2018 оны 3 дугаар сар Тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү. <u>www.audit.mn</u> <i>Аудитын тайлан</i> <i>дүгнэлттэй холбоотой</i> <i>асуудлаар нэмж</i> <i>тодруулах, асууж лавлах</i> <i>зүйл байвал 261749,</i> <i>260949 дугаарын утас,</i> <i>факсаар харилцана уу.</i> Хаяг: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Чингэлтэй дүүрэг,</i> <i>Бага тойруу-3</i> <i>Засгийн газрын</i> <i>ІҮ байр</i> <i>Улаанбаатар хот 15160</i> <i>Монгол Улс</i>	Товчилсан үгийн жагсаалт.....	3
	Аудит хийх үндэслэл.....	4
	Аудитын зорилт	4
	Аудитын хамарсан хүрээ.....	4
	Аудитын арга зүй.....	4
Бүлэг. 1 Гэрээлэгч хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөөгүй, хөрөнгө оруулалтын гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй тусгаагүй байна. 1.1. Гэрээлэгч хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөхгүй байна..... 1.2. Хөрөнгө оруулалтын гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй тусгаагүй байна..... 1.3. Аудитаар 2015, 2016 онд нийт 13,918,703 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохоор баталгаажуулав.....	Үндсэн мэдээлэл.....	5-9
		9-12
		9-9
		9-11
		11-12
	Бүлэг. 2 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна. 2.1. Гэрээлэгчийн ӨНЗ-ын тайланд тусгагдсан хайгуулын талбайд хийгдсэн ажлын тайланг гео мэдээллийн санд бүртгэсэн ч хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна..... 2.2. АМГТГ гэрээт талбайд гүйцэтгэсэн ажлын холбогдох мэдээлэл, тайлан баримт, материалд болон хийж гүйцэтгэсэн ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.....	12-14
		12-14
		14
	Дүгнэлт.....	15
	Зөвлөмж.....	16
	Холбогдох байгууллагын санал.....	17-18
	Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал.....	19
	Хавсралт 1.....	20
	Хавсралт 2.....	21



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГТГ	Газрын тосны газар /хуучнаар/
ГХХ	Геологи хайгуулын хэлтэс
ЗГ	Засгийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЗУХ	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УИХ	Улсын Их Хурал
ХШҮСХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ статистикийн хэлтэс
ӨНЗ	Өртөг нөхөгдөх зардал

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Гэрээлэгчийн 2015 онд хайгуулын ажлын төлөвлөгөө батлуулсан, хайгуулын ажил гүйцэтгэсэн эсэх мэдээлэл
Хүснэгт 2	Гэрээлэгчийн 2015 онд хайгуулын ажлын төлөвлөгөө батлуулсан, хайгуулын ажил гүйцэтгэсэн эсэх мэдээлэл



Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.21-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн 2015, 2016 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасныг шалган баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч 2015, 2016 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөж, хууль журмын дагуу гүйцэтгэж, хийсэн ажлын хөрөнгө оруулалт өртөг нөхөгдөх зардлыг үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх;
- Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад АМГТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Геологи, хайгуулын хэлтэс, Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Вульф петролеум” ХХК, “Петроматад Инвест Лимитед” ХХК, “Зон Хэн Юу Тиан” ХХК, “Эн Пи Ай” ХХК, “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК-ийн Санхүү, бүртгэлийн хэлтсийн 2015, 2016 оны өртөг нөхөгдөх зардлын санхүүгийн тайлан, хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээний холбогдох заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон АДБОУС 100, 400, 4000, Төрийн хяналт шалгалтын стандарт, аудитын арга зүйг ашиглав.

Аудитаар газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн 2015, 2016 оны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулахаар бэлтгэсэн тайлан нь алдаагүй илэрхийлэгдсэн талаарх үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд ГТГ-аар /хуучнаар/ баталгаажуулсан тухайн жилийн хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв, гүйцэтгэсэн ажлын тайланг ажил гүйлгээ тус бүрээр нь анхан шатны баримттай тулган баталгаажуулах, давтан тооцоолох, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа, тайлбар авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэв.

Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааны материалыг ажлын баримтанд хавсаргав.



Үндсэн мэдээлэл

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 31 талбай ялгаснаас өнөөгийн байдлаар 22 талбайд 19 гэрээлэгч аж ахуйн нэгж (компани) Бүтээгдэхүүн хуваах гэрээг Ашигт малтмал, газрын тосны газартай байгуулан, Засгийн газраар батлуулан ажиллаж байна. Үүнээс 2 гэрээлэгчийн 2 талбай нь тайлант хугацаанд хамрагдахгүй болно. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай тус бүрээр жилийн ажлын төлөвлөгөө, төсөв баталж, хайгуулын ажил гүйцэтгэдэг бөгөөд цаашид “талбай”-аар тэмдэглэсэн болно.

Гэрээлэгчийн 2015 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлуулсан, хайгуулын ажил гүйцэтгэсэн эсэх мэдээлэл

/Хүснэгт 1/

№	Гэрээлэгч компани	БХГ-т талбай	Хөтөлбөр төсөв батлагдсан огноо	2015 онд хайгуулын ажил хийсэн эсэх	Тайлбар
1	Петроматад Инвест Лимитэд ХХК	Матад XX	2015.03.31	Ажил хийгээгүй	Аудитаар үйл ажиллагааны тайланг баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/.
2	Шейман ХХК	Нялга XVI	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	Орон нутгийн эсэргүүцлээс болж, 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй. УУХҮЯ-нд 2017.01.25-ны 2/5 албан бичиг явуулсан боловч шийдвэрлэгдээгүй байна.
3	Гоби энерги партнерс Гмбх ХХК	Зүүнбаян XIV	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	Хөрөнгө оруулагч DWM компани дампуурсан учир гэрээлэгчийн хүсэлтээр АМГТГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны 1/8188 БХГ цуцлах тухай албан бичиг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.
4	Гоби энерги партнерс Гмбх ХХК	Цагаан-Элс XIII	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	Аудитаар баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/.
5	Зон Хэн Юу Тиан ХХК	Галба XI	2015.03.26	2014-2015 онд 358.9 км ² талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийсэн	Тайлан баталгаажуулах хугацаанд санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал ирүүлээгүй тул баталгаажуулаагүй болно.
6	Шунхлай энерги ХХК	Сулин-хээр XXIII	2015.03.27	2 хэмжээст чичирхийллийн судалгаа 480 тууш км-т, Геологийн зураглал, маршрутын ажил хийсэн.	Тайлан баталгаажуулах хугацаанд санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал ирүүлээгүй тул баталгаажуулаагүй болно.
7	Импайр газ Монголиа ХХК	Борзон VII	2014.12.25	Ажил хийгээгүй	Тайлан баталгаажуулах хугацаанд санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал ирүүлээгүй тул баталгаажуулаагүй болно.
8	Эн Пи Ай ХХК	Хөх нуур XVIII	2015.02.04	СН18-РЗ цоонгог туршилт хийсэн.	Аудитаар баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/.
9	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд ХХК	Богд IV	2015.03.31	Агаарын градиаметрийн судалгаа /FTG/ 16259 км-т, 2 хэмжээст чичирхийллийн судалгаа 1085 км-т хийсэн	Аудитаар баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/.
10	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд ХХК	Онги V	2015.03.31	Агаарын градиаметрийн судалгаа /FTG/ 5730 км-т,	Аудитаар баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/.
11	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Увс I	2015.05.14	Соронзон теллурийн судалгаа 182 физик цэгт хийсэн. Хайгуулын 2 цоонгог өрөмдсөн.	Тайлан баталгаажуулах хугацаанд санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал ирүүлээгүй тул баталгаажуулаагүй болно.
12	Хонгконг Вэллэж Индастриал ХХК	Хэрлэн-тохой XXVIII	2015.07.06	Ажил хийгээгүй	
13	Ренова Илч ХХК	Хар ус II	2015.08.03	Ажил хийгээгүй	
14	Сансрын геологи хайгуул ХХК	Төхөм X хойд	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	АМГТГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны 1/8188 БХГ цуцлах тухай албан бичиг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.
15	Сансрын геологи хайгуул ХХК	Цайдам XXVI	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	



16	Магнай трейд ХХК	Баян-түмэн XVII	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	2015 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн уулзалтын протоколоор 2015.01.01-2015.12.31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаагаар түр зогсоосон байна.
17	Монголиа шин ий энерги ХХК	Дарьганга XXIV	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	
18	Монголын алт ХХК	Төхөм Х урд	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	2015 оны 3 дугаар сарын 18-ны 1-303 албан бичгээр “гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай” шаардлага хүргүүлж байсан.
19	Вульф петролиум ХХК	Сүх-баатар XXVII	2015.03.30	Ажил хийгээгүй	
20	Өмнөд монголын газар нутгийн тос ХХК	Номгон IX	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	
Нийт			11		

Эх сурвалж: АМГТГ-ын 2018 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 1/123 албан бичиг, хариуцсан мэргэжилтнүүдийн тайлан, тайлбараас.

Дээрх 20 талбайг хөтөлбөр, төсөв батлуулсан, хайгуулын ажил хийсэн эсэхийг ангилж харуулбал:

БХГ-т 20 талбай		Тоо	Хайгуулын ажил хийсэн эсэх		Тоо
Хайгуулын ажлын 2015 оны хөтөлбөр төсөв	Батлуулсан	11	Үүнээс:	Ажил хийсэн	6
				Ажил хийгээгүй	5
	Батлуулаагүй	9		Ажил хийгээгүй	9
Нийт		20			20

Тайлбар: Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай тус бүрээр хөтөлбөр төсөв баталж, хайгуулын ажил гүйцэтгэдэг бөгөөд цаашид “талбай”-аар нь тэмдэглэсэн болно.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 19 гэрээлэгч компанийн 20 талбайгаас 2015 онд 11 талбай нь хөтөлбөр төсвөө батлуулж, 9 нь батлуулаагүй байна.

Хөтөлбөр, төсвөө батлуулсан 11 талбайн 6 нь хайгуулын ажил хийж, 5 нь ажил хийгээгүй байна.

Үүнээс “Магнай трейд” ХХК 2015 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн ГТГ /хуучнаар/ гэрээлэгчийн уулзалтын протоколоор 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хайгуулын ажлыг 1 жилийн хугацаагаар хайгуулын ажлыг түр зогсоосон байна.

“Шейман” ХХК орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс болж, 2013 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй. Энэ тухай АМГТГ-ын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/5 тоот албан бичиг УУХҮЯ-нд явуулсан боловч шийдвэрлэгдээгүй байна.

“Гоби энерги партнерс Гмбх” ХХК-ийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч компани нь дампуурсан, “Сансрын геологи хайгуул” ХХК “Төхөм Х” хойд, “Цайдам XXVI” талбайн БХГ-г шинэчлэхээс татгалзаж, 2 талбайг буцааж өгөх зэрэг шалтгаанаар АМГТГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/8188 тоот албан бичгээр БХГ цуцлах тухай албан бичгийг УУХҮЯ-нд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй тул 2015, 2016 онд хөтөлбөр төсөв батлуулаагүй, хайгуулын ажил гүйцэтгээгүй байна.

“Шунхлай энерги” ХХК, “Импайр газ Монголиа” ХХК, “Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК ГТГ-аар хөтөлбөр, төсвөө батлуулж, тодорхой ажил гүйцэтгэж, ГТГ-т өртөг нөхөгдөх зардлын тайлангаа хүлээлгэж өгсөн ч аудитын баталгаажуулах хугацаанд санхүүгийн тайлан болон анхан шатны баримтыг ирүүлээгүй тул өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалтыг хийгээгүй болно.



Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-г Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан “Смарт ойл” ХХК-ийн “Эргэл XII” талбай, 2016 оны 6-р сарын 20-ны өдрийн 3Г-ын 337 дугаар тогтоолоор баталж, тусгай зөвшөөрлөө 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдөр авсан “Макс ойл” ХХК-ийн “Ар булаг ХХIX” тайлант хугацаанд хамрагдахгүй болно.

Компаниудын 2016 онд хайгуулын ажлын төлөвлөгөө батлуулсан,
хайгуулын ажил гүйцэтгэсэн эсэх мэдээлэл

/Хүснэгт 2/

№	Гэрээлэгч компани	БХГ-т талбай	Төсөв төлөвлөгөө батлагдсан эсэх	2016 онд хайгуулын ажил хийсэн эсэх	Тайлбар
1	Петро матад ХХК	Матад XX	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	АМГТГ-ын даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны 59 дүгээр тушаал 1 жилийн хугацаагаар түр зогсоосон.
2	Шейман ХХК	Нялга XVI	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	Орон нутгийн эсэргүүцлээс болж, 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй. УУХҮЯ-нд 2017.01.25-ны 2/5 албан бичиг явуулсан боловч шийдвэрлэгдээгүй.
3	Гоби энерги партнерс Гмбх ХХК	Зүүнбаян XIV	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	Хөрөнгө оруулагч DWM компани дампуурсан учир гэрээлэгчийн хүсэлтээр АМГТГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны 1/8188 БХГ цуцлах тухай албан бичиг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.
4	Гоби энерги партнерс Гмбх ХХК	Цагаан-Элс XIII	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	
5	Зон Хэн Юу Тиан ХХК	Галба XI	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	АМГТГ-ын даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны 59 дүгээр тушаал 1 жилийн хугацаагаар түр зогсоосон.
6	Шунхлай энерги ХХК	Сулин-хээр XXIII	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	АМГТГ-ын даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны 59 дүгээр тушаал 1 жилийн хугацаагаар түр зогсоосон.
7	Импайр газ Монголиа ХХК	Борзон VII	2016.03.03	Ажил хийгээгүй	
8	Эн Пи Ай ХХК	Хөх нуур XVIII	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	2016 онд хайгуулын ажлын хөтөлбөр боловсруулсан боловч АМГТГ-ын удирдлага болон мэргэжилтнүүдийн саналын зөрүүгээс шалтгаалан удааширч тухайн онд батлуулаагүй.
9	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд ХХК	Богд IV	2016.03.31	2 хэмжээст чичирхийллийн судалгаа 174 тууш км-т хийсэн, Агаарын градиаметрийн судалгаа /FTG/ 16259 км судалгааны тайллын ажил хийсэн	Аудитаар баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/
10	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд ХХК	Онги V	2016.03.31	2 хэмжээст чичирхийллийн судалгаа 174 тууш км-т хийсэн, Агаарын градиаметрийн судалгаа /FTG/ 16259 км судалгааны тайллын ажил, Хүндийн хүчний судалгааг 123 цэгт хийсэн.	Аудитаар баталгаажуулсан. /Хавсралтаас үзэх/
11	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Увс I	2016.03.30	138 тууш км-т 2Д чичирхийллийн судалгаа хийсэн.	Тайлан баталгаажуулах хугацаанд санхүүгийн тайлан, анхан шатны баримт материал ирүүлээгүй тул баталгаажуулаагүй болно.
12	Хонгконг Вэллэж Индастриал ХХК	Хэрлэн-тохой XXVIII	2016.03.31	Ажил хийгээгүй	
13	Ренова Илч ХХК	Хар ус II	2016.03.31	Ажил хийгээгүй	
14	Сансрын геологи хайгуул ХХК	Төхөм X хойд	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	АМГТГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны 1/8188 БХГ цуцлах тухай албан бичиг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.
15	Сансрын геологи хайгуул ХХК	Цайдам XXVI	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	
16	Магнай трейд ХХК	Баян-түмэн XVII	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	АМГТГ-ын даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны 59 дүгээр тушаал 1 жилийн хугацаагаар түр зогсоосон.



17	Монголиа шин ий энерги ХХК	Дарьганга ХХIV	2016.04.25	Ажил хийгээгүй	АМГТГ-ын даргын 2016 оны 10 дугаар сарын 18-ны а/16 дугаар тушаалаар 2016.01.01-2016.12.31-ний хооронд 1 жилийн хугацаагаар түр зогсоосон.
18	Монголын алт ХХК	Төхөм Х урд	Батлуулаагүй	Ажил хийгээгүй	2015 оны 3 дугаар сарын 18-ны 1-303 албан бичгээр “гэрээний хэрэгжилтийг хангуулах тухай” шаардлага хүргүүлж байсан.
19	Вульф петролиум ХХК	Сүх-баатар ХХVII	2016.03.30	Ажил хийгээгүй	
20	Өмнөд монголын газар нутгийн тос ХХК	Номгон IX	2016.03.25	Ажил хийгээгүй	
Нийт			9		

Эх сурвалж: АМГТГ-ын 2018 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 1/123 албан бичиг, хариуцсан мэргэжилтнүүдийн тайлан, тайлбараас.

Дээрх 20 талбайг хөтөлбөр, төсөв батлуулсан, хайгуулын ажил хийсэн эсэхийг ангилж харуулбал:

БХГ-т 20 талбай		Тоо	Хайгуулын ажил хийсэн эсэх		Тоо
Хайгуулын ажлын 2016 оны хөтөлбөр төсөв	Батлуулсан	9	Үүнээс	хийсэн	3
	Батлуулаагүй	11		хийгээгүй	6
				хийгээгүй	11
Нийт		20			20

Тайлбар: Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай тус бүрээр хөтөлбөр төсөв баталж, хайгуулын ажил гүйцэтгэдэг бөгөөд цаашид “талбай”-аар нь тэмдэглэсэн болно.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 2016 онд 19 гэрээлэгч компанийн 20 талбайгаас 9 талбай нь хөтөлбөр төсвөө батлуулж, 11 нь батлуулаагүй байна.

Хөтөлбөр, төсвөө батлуулсан 9 талбайн 3 нь хайгуулын ажил хийж, 6 нь ажил хийгээгүй байна.

Мөн дээрх 20 талбайгаас 2015 оны 5 талбайн, 2016 оны 3 талбайн ӨНЗ-ыг аудитаар баталгаажуулсан бөгөөд үлдэх талбайн гэрээлэгч ӨНЗ-ыг баталгаажуулаагүй шалтгааныг ангилж графикаар харуулбал:



“Петроматад Инвест Лимитед” ХХК, “Зон Хэн Юу Тиан” ХХК, “Шунхлай энерги” ХХК, “Магнай трейд” ХХК-иудын гаргасан хүсэлт, Монгол Улсын Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр



зүйлийн 9.1.20-д заасныг тус тус үндэслэн АМГТГ-ын даргын 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 59 дүгээр тушаалаар 1 жилийн хугацаагаар хайгуулын үйл ажиллагааг түр зогсоосон байна.

Мөн дээрх хуулийн заалтууд болон хайгуулын “Дарьганга XXIV” талбайн БХГ-ний 23.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Монголиа шин ий энерги” ХХК АМГТГ-ын даргын 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн а/16 дугаар тушаалаар 1 жилийн хугацаагаар хайгуулын үйл ажиллагааг түр зогсоосон байна.

“Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК ГТГ-аар хөтөлбөр, төсвөө батлуулж, тодорхой ажил гүйцэтгэж, өртөг нөхөгдөх зардлын тайлангаа гаргаж өгсөн ч аудитын баталгаажуулах хугацаанд санхүүгийн болон анхан шатны баримтыг ирүүлээгүй тул өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалтыг хийгээгүй болно.

БҮЛЭГ. 1 ГЭРЭЭЛЭГЧ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЛГЭЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ТУСГААГҮЙ БАЙНА.

1.1. Гэрээлэгч хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөхгүй байна.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т гэрээлэгч жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлнэ, Бүтээгдэхүүн хуваах гэрээний 6 дугаар зүйлийн 6.3-т “гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор, цаашид гэрээт жил эхлэхээс ерээс (90) доошгүй хоногийн өмнө гэрээлэгч нь тухайн гэрээт жилд гүйцэтгэх хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг нэр төрөл бүрээр нарийвчлан боловсруулж, ГТГ-аар батлуулна. Мөн өмнөх жилд хийсэн ажлын тайланг танилцуулж, ГТГ-т өгнө” тус тус заасан байна.

Гэтэл гэрээлэгч компаниудаас 2015 онд 9 гэрээт талбай буюу 45 хувь, 2016 онд 11 гэрээт талбай буюу 55 хувь нь хөтөлбөр, төсвөө ГТГ-аар /хуучнаар/ хянуулж, батлуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 болон БХГ-ний дээрх заалт зөрчигдөж байна.

Мөн гэрээлэгч компаниудын 2015 онд 11 гэрээт талбайд нийт 60,605,448 ам.долларын хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв батлуулснаас 6 гэрээт талбайд 24,443,123 ам.долларын хайгуулын ажил хийж, ажлын гүйцэтгэл 40,3 хувь, 2016 онд 9 гэрээт талбайд нийт 45,915,468 ам.долларын хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв батлуулснаас 3 гэрээт талбайд 9,662,722 ам.долларын хайгуулын ажил хийж, ажлын гүйцэтгэл 20,9 хувьтай байна.

Энэ нь гэрээлэгч компаниуд тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөөгүй, батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу хайгуулын ажлыг бүрэн хийгээгүй байна.

1.2. Хөрөнгө оруулалтын гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй тусгаагүй байна.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч компаниуд 2015, 2016 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөөгүй, хөрөнгө оруулалтын гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй тусгаагүй байна.

Гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 2015 онд 3,714,329, 2016 онд 1,115,419 ам.долларыг хасаж баталгаажуулав. Үүнд:



“Эн Пи Ай” ХХК нь “Хөх нуур-ХVIII” талбайд 2015 онд батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу 2014 оны 004 тоот гэрээний дагуу туршилтын цооног өрөмдлөгийн зардал 729,294 ам.долларыг мөнгөн хөрөнгийн дансаар шилжүүлээгүй байхад зардалд бичиж өглөгт тусгасан нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д *“хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”* гэсэн заалтыг үндэслэн өртөг нөхөгдөх зардлаас хасав.

“Вульф петролеум” ХХК-ийн “Сүхбаатар ХХVII” талбайн 2015 оны өртөг нөхөгдөх зардлаас 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хийгдсэн гэрээний дагуу зөвлөх үйлчилгээний зардал 220,000 ам.долларыг толгой компаниас “МНА Petroleum Consultants LLC”-руу шууд шилжүүлж газрын тосны өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан нь Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д *“хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”* гэсэн заалтыг үндэслэн өртөг нөхөгдөх зардлаас хасаж баталгаажуулав.

2015 онд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК-ийн “Онги V” талбайн хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлаас толгой компани болох “Петроматад Инвест Лимитед” ХХК-иас шууд шилжүүлсэн дараах зардлуудыг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д *“хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”*, 36 дугаар зүйлийн 36.2-д *“Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана”* гэсэн заалтыг тус тус үндэслэн нийт 605,068 ам долларыг өртөг нөхөгдөх зардлаас хасав. Үүнд:

1. Бүрэн хэмжээст агаарын градиометрийн судалгааны ажлын зардалд шилжүүлсэн 560,589 ам.доллар;
2. Гадаад, дотоод томилолтын зардал 15,667 ам.доллар;
3. Нөхөгдөх зардлын 5 хувь 28,812 ам.доллар.

2015 онд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК-ийн “Богд IV” талбайн хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлаас толгой компани болох “Петроматад Инвест Лимитед” компаниас шууд шилжүүлсэн дараах зардлуудыг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д *“хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”*, 36 дугаар зүйлийн 36.2-д *“Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана”* гэсэн заалтыг тус тус үндэслэн нийт 2,159,967 ам долларыг өртөг нөхөгдөх зардлаас хасав. Үүнд:

1. Бүрэн хэмжээс агаарын градиометрийн судалгаа 1,857,492 ам.доллар;
2. 2 хэмжээст чичирхийллийн мэдээлэл боловсруулах 168,287 ам.доллар;
3. Олон улсын нислэг болон зочид буудлын төлбөрт 31,333 ам.доллар;
4. Нөхөгдөх зардлын 5 хувь 102,855.

Мөн 2016 онд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК-ийн “Онги V” талбайн хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлаас толгой компани болох “Петро Матад Инвест Лимитед” компаниас шууд шилжүүлсэн дараах зардлуудыг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д *“хөрөнгө оруулалт, борлуулалтын*



орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”, 36 дугаар зүйлийн 36.2-д “Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана” гэсэн заалтыг тус тус үндэслэн нийт 443,481 ам.долларыг өртөг нөхөгдөх зардлаас хасав. Үүнд:

1. 2 хэмжээст чичирхийллийн судалгааны болон боловсруулалтын ажлын зардал 91,504 ам.доллар;
2. Геологи, геохимийн ажлын зардалд 17,745 ам.доллар;
3. Үйлчилгээний хөлс болон гадаад, дотоод томилолтын зардал 313,114 ам.доллар;
4. Нөхөгдөх зардлын 5 хувь 21,118 ам.доллар.

2016 онд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК-ийн “Богд IV” талбайн хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлаас толгой компани болох “Петроматад Инвест Лимитед” компаниас шууд шилжүүлсэн дараах зардлуудыг Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6-д “хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах”, 36 дугаар зүйлийн 36.2-д “Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана” гэсэн заалтыг тус тус үндэслэн нийт 671,938 ам.долларыг өртөг нөхөгдөх зардлаас хасав. Үүнд:

1. 2 хэмжээст чичирхийллийн судалгааны болон боловсруулалтын ажлын зардал 293,651 ам.доллар;
2. Үйлчилгээний хөлс болон гадаад дотоод томилолтын зардал 346,290 ам.доллар;
3. Нөхөгдөх зардлын 5 хувь 31,997.

Ашигт малтмал, газрын тосны газарт өртөг нөхөгдөх зардлын тайлан ирүүлсэн 2015 оны 5 компанийн нийт 12,922,169 ам.долларын хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 3,714,329 ам.долларыг буюу 28,7 хувийг, 2016 оны 3 компанийн нийт 5,826,282 ам.долларын хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 1,115,419 ам.долларыг буюу 19,1 хувийг хасаж тооцохоор баталгаажуулав.

1.3. Аудитаар 2015, 2016 онд нийт 13,918,703 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохоор баталгаажуулав.

Ашигт малтмал, газрын тосны газарт өртөг нөхөгдөх зардлын тайлан ирүүлсэн 2015 оны 5 компанийн нийт 12,922,169 ам.долларын хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 9,207,840 ам.доллар, 2016 оны 3 компанийн нийт 5,826,282 ам.долларын хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 4,710,863 ам.доллар, нийт 13,918,703 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохоор баталгаажуулав. (Хавсралт 1)

“Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК-ийн “Богд IV”, “Онги V” талбайн 2015, 2016 оны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудитаар 10,755,723 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд баталгаажууллаа.

2015 оны “Эн Пи Ай” ХХК нь “Хөх нуур-XVIII” талбайд зарцуулсан 530,289, “Вульф петролеум” ХХК-ийн “Сүхбаатар XXVII” талбайд зарцуулсан 82,358 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд баталгаажууллаа.



“Петроматад Инвест Лимитэд” ХХК-ийн “Матад ХХ” талбайд 2015 онд зарцуулсан 142,726, 2016 онд зарцуулсан 58,823 ам.долларын зардлыг өртөг нөхөхөөр тулгаж баталгаажуулав.

“Зон Хэн Юу Тиан” ХХК нь “Галба XI” талбайд 2015 оны аудитаар авч үзэхээр хойшлогдсон зардал болох 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, боловсруулалтын 2,348,784 ам.долларын зардлыг өртөг нөхөхөөр тулгаж баталгаажууллаа.

БҮЛЭГ.2 ГАЗРЫН ТОСНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ГЭРЭЭЛЭГЧИЙН АЖЛЫН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙГ БАТЛАХ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

2.1. Гэрээлэгчийн ӨНЗ-ын тайланд тусгагдсан хайгуулын талбайд хийгдсэн ажлын тайланг гео мэдээллийн санд бүртгэсэн ч хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Газрын тосны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 9 зүйлийн 9.1.3¹-д газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын тосны эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийг заасан.

Гэтэл газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 2015 онд 17 гэрээлэгч компанийн 20 талбайгаас 2015 онд 14 гэрээт талбайд буюу 70 хувьд, 2016 онд 17 гэрээт талбайд буюу 85 хувьд хайгуулын ажил хийгээгүй байгаа нь АМГТГ гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээлэгчдэд эрх үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх, тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардлын тайланг хянаж, нэгтгэх зэрэг чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

Гэрээлэгч компаниудын хөтөлбөр, төсвийн гүйцэтгэлийг диаграммаар харуулбал:



АМГТГ-тай 2015 онд 11 талбайд нийт 60,605,448 ам.долларын хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв батлуулснаас 6 талбайд 24,443,123 ам.долларын хайгуулын ажил хийж, ажлын гүйцэтгэл 40,3 хувь, 2016 онд 9 талбайд нийт 45,915,468 ам.долларын хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв батлуулснаас 3 талбайд 9,662,722 ам.долларын

¹газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;



хайгуулын ажил хийж, ажлын гүйцэтгэл 20,9 хувьтай байгаагаас дүгнэж үзвэл АМГТГ гэрээлэгчээс ирүүлж байгаа өртөг нөхөгдөх зардлын тайланг төлөвлөгөө, төсвийн дагуу хяналт тавьж хүлээж аваагүй байна.

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн уналт болон нийгэм эдийн засгийн хүчин зүйл нөлөөлсөн гэх шалтгаанаар 2015, 2016 онд ГТГ-аар хөтөлбөр, төсвөө батлуулсан ч хайгуулын ажлаа хийгээгүй гэрээлэгч компаниудыг хүснэгтээр харуулав.

№	Он	Тоо	Гэрээлэгч компанийн нэр	Тайлбар
1	2015	5	“Петро Матад Инвест Лимитед” ХХК, “Импайр газ Монголиа” ХХК, “Хонгконг Вэллэж Индастриал” ХХК, “Ренова Илч” ХХК, “Вульф петролиум” ХХК	“Петро Матад Инвест Лимитед” ХХК үйл ажиллагааны зардал тайлагнаж баталгаажуулсан.
2	2016	6	“Импайр газ Монголиа” ХХК, “Хонгконг Вэллэж Индастриал” ХХК, “Ренова Илч” ХХК, “Вульф петролиум” ХХК, “Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК, “Монголиа шин ий энерги” ХХК	“Монголиа шин ий энерги” ХХК 2016 онд хайгуулын ажлын түр зогсоох чөлөө авсан.

ГТГ-аар /хуучнаар/ 2015, 2016 онд жилийн ажлын хөтөлбөр, төсвөө батлуулаагүй, хөтөлбөр, төсвөө батлуулсан ч хайгуулын ажлаа хийгээгүй “Хонгконг Вэллэж Индастриал” ХХК, “Ренова Илч” ХХК, “Вульф петролиум” ХХК, “Монголиа шин ий энерги” ХХК, “Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК, “Импайр газ Монголиа” ХХК зэрэг гэрээлэгчдийн газрын тосны тухай хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар ямар арга хэмжээ авсан, дээрх гэрээлэгчид ямар шалтгаанаар хөтөлбөр төсвөө батлуулаагүй, хайгуулын ажил хийхгүй байгаа талаар тайлбар, баримт материал шаардсан боловч ГХХ-ээс гаргаж өгсөнгүй.

Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан “гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих”, 9.1.4²-д “гэрээлэгчдэд эрх үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх”, “9.1.8³-д “Гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардлын ... тайланг хянаж, нэгтгэх” зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

Тухайн үед Д.Үүрийнтуяа 2014 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 173 дугаар тушаалаар, Б.Баатарцогт 2016 оны 2016 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тушаалаар АМГТГ-ын даргаар тус тус томилогдон ажиллаж байсан бөгөөд хариуцсан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитаар Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан “гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих”, 9.1.8⁴-д “Гэрээлэгчийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардлын ... тайланг хянаж, нэгтгэх” үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн АМГТГ-ын ГХХ, ТЗУХ-ийн мэргэжилтнүүдэд хариуцлага тооцох албан шаардлагыг АМГТГ-ын даргад хүргүүлээ.

Гэрээлэгчийн ӨНЗ-ын тайланд тусгагдсан хайгуулын талбайд хийгдсэн ажлын тайлан нягталж үзвэл, 2015 онд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” ХХК-ийн “Богд IV” талбайд 16259 километрт агаарын гриадиометрийн судалгааны хээрийн болон боловсруулалтын ажлын тайланг гео мэдээллийн сангийн 4150012 дугаарт, 1085 тууш километрт 2 хэмжээст чичирхийллийн хээрийн хэмжилт болон суурин боловсруулалтын ажлын тайланг 4150013, 4150009 дугаарт бүртгэсэн байна.

Харин 2016 онд “Богд IV” талбайд 16259 километрт агаарын гриадиометрийн судалгааны боловсруулалт, тайллын ажлын тайланг гео мэдээллийн сангийн 4150012 дугаарт, 174 тууш километрт өгөгдлийн нягтралыг нэмэгдүүлэх зорилгоор хийх 2 хэмжээст чичирхийллийн хээрийн хэмжилтийн ажлын тайланг 4160006, 4160009

² Тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрх үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх;

³ Гэрээлэгчийн тухай жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж, нэгтгэх;

⁴ Гэрээлэгчийн тухай жилийн хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянаж, нэгтгэх.



бүртгэсэн бол тус 2 хэмжээст чичирхийллийн боловсруулалтын ажлын тайланг АМГТГ хүлээж авсан боловч гео мэдээллийн санд бүртгээгүй байна.

Мөн тус компанийн “Онги V” талбайд 2015 онд 5730 километрт агаарын гриадиометрийн судалгааны хээрийн ажлын тайланг гео мэдээллийн сангийн 5150005 дугаарт бүртгэсэн байна. Харин 2016 онд хийсэн 5730 километрт агаарын гриадиометрийн судалгааны боловсруулалт, тайллын ажлын тайлан, 256 тууш километрт 2 хэмжээст чичирхийллийн хээрийн хэмжилт болон боловсруулалтын ажил, 123 физик цэгт хүндийн хүчний судалгааны ажлын тайланг АМГТГ хүлээж авсан боловч гео мэдээллийн санд бүртгээгүй байна.

“Зон Хэн Юу Тиан” ХХК нь “Галба XI” талбайд 2015 онд 358.92 км² 2014 онд Өлгийн хотгорт гүйцэтгэсэн 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын багцлалтын өмнөх миграцийн үр дүнгийн тайланг гео мэдээллийн сангийн 1110006 дугаарт бүртгэсэн байна.

2.2. АМГТГ гэрээт талбайд гүйцэтгэсэн ажлын холбогдох мэдээлэл, тайлан баримт, материалд болон хийж гүйцэтгэсэн ажилд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

АМГТГ-ын ХШҮСХ гэрээт талбайд гүйцэтгэсэн ажлын холбогдох мэдээлэл, тайлан баримт, материал болон хийж гүйцэтгэсэн ажилд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн эсэх талаар холбогдох мэргэжилтнүүдээс тодруулахад хариуцаж ажиллаж байсан мэргэжилтэн байхгүй, архивын баримт материал цэгцгүй, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

Хариуцсан ажлаа тайлагнаагүй, баримт материалаа аудитад гаргаж өгөөгүй ХШҮСХ-ийн даргад хариуцлага тооцуулах албан шаардлагыг АМГТГ-ын даргад хүргүүлэв.

Мөн гэрээлэгчийн БХГ-ний хэрэгжилтийг санхүү, геологи хайгуулын хэлтэсүүд хариуцсан асуудлаар хяналтыг хэрэгжүүлдэг ч, гэрээлэгчийн гэрээний хэрэгжилтийг нэгтгэж дүгнэдэг нэгж байхгүй байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т гэрээлэгч жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэхээр заасан байхад гэрээлэгч компаниудын 2015 онд 9 гэрээт талбай буюу 45 хувь, 2016 онд 11 гэрээт талбай буюу 55 хувь нь хөтөлбөр, төсвөө ГТГ-аар /хуучнаар/ хянуулж, батлуулаагүй нь Газрын тосны тухай хуулийн дээрх заалт зөрчигдөж байна.
2. Мөн гэрээлэгч компаниудын 2015 онд 11 гэрээт талбайд нийт 60,605,448 ам.долларын хайгуулын ажлын хөтөлбөр, төсөв батлуулснаас 6 гэрээт талбайд 24,443,123 ам.долларын хайгуулын ажил хийж, ажлын гүйцэтгэл 40,3 хувь, 2016 онд 9 гэрээт талбайд нийт 45,915,468 ам.долларын хайгуулын ажлын хөтөлбөр төсөв батлуулснаас 3 гэрээт талбайд 9,662,722 ам.долларын хайгуулын ажил хийж, ажлын гүйцэтгэл 20,9 хувьтай байгаа нь гэрээлэгч компаниуд тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөөгүй, батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу хайгуулын ажлыг бүрэн хийгээгүй байна.
3. Ашигт малтмал, газрын тосны газарт өртөг нөхөгдөх зардлын тайлан ирүүлсэн 2015 оны 5 компанийн нийт 12,922,169 ам.долларын хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 3,714,329 ам.долларыг буюу 28,7 хувийг, 2016 оны 3 компанийн нийт 5,826,282 ам.долларын хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайлангаас 1,115,419 ам.долларыг буюу 19,1 хувийг хасаж тооцохоор баталгаажуулсан ба гэрээлэгч хөрөнгө оруулалтын гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй тусгаагүй байна.
4. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 17 гэрээлэгч компанийн 20 талбайгаас 2015 онд 14 талбайд буюу 70 хувьд, 2016 онд 17 талбайд буюу 85 хувьд нь хайгуулын ажил хийгээгүй байгаа нь АМГТГ гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээлэгчдэд эрх үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх, тухайн жилийн хөрөнгө оруулалт, зардлын тайланг хянаж, нэгтгэх зэрэг чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.
5. АМГТГ-ын ХШҮСХ 2015, 2016 онд гэрээт талбайд гүйцэтгэсэн ажлын холбогдох мэдээлэл, тайлан баримт, материал болон хийж гүйцэтгэсэн ажилд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

1. Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлээгүй, хөтөлбөр төсвөө батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчийн БХГ-г цуцлах саналыг ЗГ-т хүргүүлэн, зохих арга хэмжээ авч ажиллах;
2. Гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний зардлын болон ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, газрын тосны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах журам, зааврыг шинээр боловсруулж батлуулах, мөрдөж ажиллах талаар АМГТГ-т үүрэг чиглэл өгч ажиллах.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргад:

1. Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлээгүй, хөтөлбөр төсвөө батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчийн БХГ-г цуцлах саналыг УУХҮЯ-нд хүргүүлэн, зохих арга хэмжээ авч ажиллах;
2. Газрын тосны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах журам, зааврыг шинээр боловсруулж батлуулах, мөрдөж ажиллах;
3. Гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний зардлын болон ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.



Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

15170 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын төлбөй 3, Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70
И-мэйл: info@mgam.gov.mn

Зам. 04.04 № 9/2646.
Танай Зам. 05.06-ны № 04/829 -г

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БОЛДБААТАР ТАНАА

Танай 2018 оны 03 сарын 26-ны өдрийн 07/829 тоот албан бичгээр ирүүлсэн газрын тосны өртөг нөхөгдөх зардалд баталгаажуулалт хийх нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын ажлын хэсэгт манай байгууллагын мэргэжлийн хүмүүс оролцож шаардлагатай мэдээ мэдээлэл, дүгнэлтийг гаргаж хамтран ажилласан.

Аудитын ажлын дүн, тайлангийн төслийг хамтарч ажилласан ажлын хэсгээр хэлэлцэж гишүүдийн санал, тайлбарыг аваагүй, зарим асуудалд тухайлбал гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлыг хууль зүйн тодорхой үндэслэлгүйгээр өртөг нөхөгдөх зардлаас хассан, ажлын хэсгийн гишүүд хавсралт тооцоотой танилцаагүй (дүгнэлт гаргасан сүүлийн тооцоог) зэрэг үндэслэлээр аудитын тайланг бүрэн зөвшөөрөх боломжгүй байна.

Иймд ажлын хэсгээр аудитын дүнг ярилцаж, харилцан ойлголцож холбогдох хууль журмын хүрээнд шийдвэрлэхийг хүсэж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ДАШПҮРЭВ

10 2391



Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн саналд ҮАГ-аас өгөх тайлбар:

Газрын тосны өртөг нөхөгдөх зардалд баталгаажуулалт хийх аудитын тайлангийн төсөлд саналаа ирүүлэх тухай манай 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 07/829 тоот албан бичгийн хариуд АМГТГ-аас 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 9/2645 тоот албан бичгээр аудитын дүнг ярилцаж, харилцан ойлголцож, холбогдох хууль журмын хүрээнд шийдвэрлэхийг хүссэний дагуу уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад:

Үндэсний аудитын газраас:

1. НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Болдбаатар,
2. Аудитор Д.Дорждулам,
3. Аудитор Л.Нямтөмөр,

Ашигт малтмал, газрын тосны газраас:

1. ТЗУХ-ийн дарга Б.Дашпүрэв,
2. ТЗУХ-ийн өртөг нөхөгдөх зардал, газрын тосны бүртгэл, тооцоо, хяналт хариуцсан мэргэжилтэн Б.Оюун, Ч.Наранцэцэг

нар оролцож, аудитын дүн, санал тайлбар болон өртөг нөхөгдөх зардал баталгаажуулахад цаашдын хамтын ажиллагааны талаар харилцан ярилцаж хурлын тэмдэглэлээр баталгаажууллаа.

АМГТГ-ын албан бичигт	ҮАГ-ын тайлбар
<i>Аудитын ажлын дүн, тайлангийн төслийг хамтарч ажилласан ажлын хэсгээр хэлэлцэж гишүүдийн санал, тайлбарыг аваагүй.</i>	Гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын өртөг нөхөгдөх зардлаас хасаж буй зардлын хуулийн үндэслэлд аудитын явцад АМГТГ-аас хамтран ажилласан холбогдох мэргэжилтнүүд санал зөрсөн тул санал, тайлбарыг хурлын тэмдэглэл хөтөлж албажуулсан болно.
<i>Гэрээлэгчийн гүйцэтгэсэн ажлын өртөг нөхөгдөх зардлаас хууль зүйн үндэслэлгүй хассан.</i>	Аудитын хүрээнд ажлын баримтаар нотлогдож байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй.
<i>Ажлын хэсэг хавсралт тооцоотой танилцаагүй.</i>	Уулзалтаар хариуцсан мэргэжилтэнг хавсралт тооцоотой танилцуулахаар тохиролцов.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 - 04 - 12

A/66

123-89 123456

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тосны 2015, 2016 оны хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулсан нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


2. Аудитын тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Д.Сумъяабазар/, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Х.Хэрлэн/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторт даалгасугай.

5. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторт, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



Хавсралт №1

ГАЗРЫН ТОСНЫ 2015, 2016 ОНЫ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

№	Компанийн нэр	Талбайн нэр	2015 он			2016		
			ӨНЗ /КМ-ын тайлан-гаар /ам.дол/	Аудитаар хасагдсан /ам.дол/	Баталгааж сан ӨНЗ /ам.дол/	ӨНЗ /КМ-ын тайлан гаар /ам.дол/	Аудитаар хасагдсан /ам.дол/	Баталгааж сан ӨНЗ /ам.дол/
1	Сентрал Азиан Петролеум корпорэйшн лимитед	Богд IV	7,283,836	2,159,967	5,123,869	2,759,881	671,938	2,087,943
		Онги V	1,584,882	605,068	979,814	3,007,578	443,481	2,564,097
2	Эн пи ай ХХК	Хөхнуур XVIII	1,259,583	729,294	530,289	Ажил хийгээгүй.		
3	Вульф петролеум ХХК	Сүхбаатар XVII	302,358	220,000	82,358	Ажил хийгээгүй.		
4	Зон хэн юу тиан ХХК	Галба	2,348,784		2,348,784	АМГТГ-ын даргын 2016.04.20 №59 түр зогссон.		
5	Петроматад Инвест Лимитед ХХК	Матад ХХ	142,726		142,726	58,823		58,823
ДҮН			12,922,169	3,714,329	9,207,840	5,826,282	1,115,419	4,710,863
НИЙТ ДҮН						2015, 2016 нийт дүнгээр		
						18,748,451	4,829,748	13,918,703



Хавсралт №2

ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ /Ам.доллар/

Д/д	Компанийн нэр	Талбайн нэр	2015			2016		
			Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Зон хэн юу тиан ХХК	Галба XI	1,234,393					
2	Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед ХХК	Онги V Богд IV	6,766,990 8,726,853	1,584,882 7,283,836	23.4 83.4	7,069,222 2,645,631	3,067,010 2,836,112	43.4 107.2
3	Шунхлай ххк	Сулинхээр XXIII	1,413,500	781,100	55.2			
4	Импайр газ монголиа ХХК	Борзон VII	8,922,790			5,004,008		
5	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Увс I	16,063,742	13,240,400	82.4	10,597,849	3,719,600	35.1
6	Хонгконг вэлтэк индастрал ХХК	Хэрлэнтохой XVIII	2,819,954			737,090		
7	Ренова-Илч ХХК	Хар-Ус II	5,163,819			7,996,028		
8	Эн пи ай ХХК	Хөх нуур XVIII	5,295,600	1,250,547	23.6			
9	Петроматад Инвест Лимитед ХХК	Матад XX	465,062					
10	Вульф петролеум ХХК	Сүхбаатар XVII	3,732,745	302,358	8.1	3,761,035		
11	Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК	Номгон IX				5,565,822		
12	Монголиа Шин ии энерги ХХК	Дарьганга XXIV				2,538,783		
	Нийт дүн		60,605,448	24,443,123	40.3	45,915,468	9,622,722	20.9